

Хууль зүйн сайдын 2014 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/89 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам”-ын дагуу тус цагдаагийн газар нь 2017 оны 01 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд “Иргэний зөвлөл” болон 19 сумын оршин суугчдад 2016 оны үйл ажиллагааны тайлангаа тавьж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар санал асуулга авч ажиллаа.

Үйл ажиллагааны тайлан тавьсан сумууд:

д/д	Тайлан тавьсан сум, баг	Тайлан тавьсан албан тушаалтан	Оролцсон иргэдийн тоо
1	Өмнөговь	Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа С.Соронзонболд	110
2	Ховд		95
3	Бөхмөрөн		81
4	Наранбулаг	Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Мишигдорж	82
5	Өлгий		90
6	Тариалан		84
7	Тэс	Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Батбаатар	61
8	Зүүнговь		93
9	Хяргас		86
10	Давс	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Мөнхбат	96
11	Сагил		86
12	Түргэн		115
13	Баруунтуруун	Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Баясал	50
14	Цагаанхайрхан		50
15	Малчин		75
16	Зүүнхангай	Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ч.Лхагвадорж, Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, цагдаагийн хошууч Ү.Баасанжав	105
17	Өндөрхангай		64
18	Завхан		82
19	Улаангом сумын 1-12 баг	Хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад А.Сайнжаргал, цагдаагийн дэслэгч А.Тогтох, цагдаагийн дэслэгч Н.Ерлан, цагдаагийн дэслэгч Л.Нямхүү	987

Цагдаагийн газрын үйл ажиллагааны тайлангийн хуралд нийт 19 сумын 2492 иргэд оролцсон байна.

УВС АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.01.10

Улаангом

Нэг. Төсвийн төсөл, зарцуулалт, болон аудит болон санхүүгийн үйл ажиллагаа

2016 оны төсвийн жилд санхүүгийн үйл ажиллагааг Монгол Улсын Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, төрийн сангийн заавар журамыг тус тус мөрдөж, зардлын зүйлийг бүлгийн дүнгээр хянаж, сар улирлын хуваарь болон зарцуулах эрхийн хүрээнд гүйлгээ хийж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ гаргаж аймгийн төрийн сангаар хянуулж хуулийн хугацаанд тогтмол гаргаж ЦЕГ-ын Санхүү, хангамжийн газарт хүргүүлж ажиллаа.

Нягтлан бодох бүртгэл болон анхан шатны баримтын бүрдэлийг 100 хувь хангаж, бүртгэлийг стандартын дагуу хөтөлж, сар улирлын тайланг хуулийн хугацаанд гаргаж, өр авлагын үлдэгдэлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажилласан.

Үнэт цаасны тайланг сард 2 удаа гаргаж, алба хаагчдын тооцоог тогтмол хийж, хагас бүтэн жилийн тооллогоор алба хаагчдын гар дээр байгаа үнэт цаасыг нүд үзэн тоолж, тасалсан торгуулийн хуудсыг мэдээлэл судалгааны сантай тулгалт хийж, ЦЕГ-ын төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, өгсөн зөвлөмжийн дагуу торгууль шийтгэврийн хуудасны төлбөрийг ажлын 3 хоногт багтааж төрийн сангийн дансанд тушааж санхүүтэй тооцоо хийх ажлыг хэвшүүлээд байна.

Тус цагдаагийн газар 2016 онд улсын төсвөөс 2029082,2 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 2092082,2 мянган төгрөгийн санхүүжилт авч, эрүүлжүүлэхийн орлого 2916,6 мянган төгрөг, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн төлбөр 2074,0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл түр саатуулсаны орлого 2283,2 мянган төгрөг, харуул хамгаалалтын орлого 49665,5 мянган төгрөг бүгд 56950,2 мянган төгрөгийг үндсэн дансанд, Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор автомашины засварын зардал 5000,0 мянган төгрөг, ЦЕГ-аас УИХ болон орон нутгийн сонгуулийн үеийн хэв журмын хамгаалалтын зардал 16415,0 мянган төгрөг, Улаангом сумыг камержуулалтын системд холбох тоног төхөөрөмж худалдан авах 360000,0 мянган төгрөг, аймгийн ГХУС-ийн зардлаас 1093,0 мянган төгрөг нийт 383165,0 төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд тус тус хүлээн авч данс бүртгэлд тусгав.

2016 онд нийт төсвийн 82,1 хувь буюу 1708736,8 мянган төгрөгийг цалингийн зардалд, НДШ 35750,6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 96339,2 мянган төгрөг, хангамж, бараа, материалын зардалд 109006,6 мянган төгрөг, нормативт зардал 8978,5 мянган төгрөг, урсгал засварын зардал-19569,0 мянган төгрөг, томилолтын зардал 21247,4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал-3732,1 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 75308,2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалын зардал 4116,5 мянган төгрөг тус тус зарцуулж нийт 2086032,4 мянган төгрөгийн зарлага гаргаж харилцах дансанд 3247,5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

2016 оны жилийн эцсийн байдлаар захиргааны журмаар баривчлагдсан иргэдийн хоногийн хураамж мянган төгрөгийн авлагатай, харилцагч байгууллага, иргэн аж ахуйн нэгжид өргүй гарсан байна.

2016 онд Улаангом сумыг хяналтын камержуулалтын системд холбох тоног төхөөрөмж, угсарч суурилуулах зардал нийт 431202,3 мянган төгрөгийн өртөг бүхий техник хэрэгсэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлсэн нисдэг камер 4029,0 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, хууль сурталчлах зорилгоор урсдаг дэлгэц бүхий самбар 5948,1 мянган төгрөг, ЦЕГ-ын Авто баазаас хуваарилсан 2 авто машин техник хэрэгсэл-64176,0 мянган

төгрөг, , ЦЕГ-ын Санхүү, хангамжийн газраас 2948,4 төгрөгийн тусгай хэрэгсэл, сум галт хэрэглэл, Хангалт үйлчилгээний төвөөс 8244,5 мянган төгрөгийн тусгай хэрэгсэл, материал тус тус хүлээн авч данс бүртгэлд тусгав.

Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор Тэс сумын соёлын төвийн 50000,0 мянган төгрөгийн өртөг бүхий музейн барилгыг цагдаагийн кобаны зориулалтаар балансаас балансад шилжүүлсэнийг барилга байгууламж дансанд, Уаз-31512 маркийн автомашин 1ш, Хууль зүйн сайдын тушаалын дагуу Тахарын албанаас 443,7 мянган төгрөгийн материал, 7666,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 668637,8 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан.

Хоёр. Гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилт, түүний үр дүн

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх нь чухал ач холбогдолтой бөгөөд тус цагдаагийн газраас орчин үеийн техник технологийг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах зорилгоор мөрдөн байцаагч болон жижүүрийн шуурхай албыг сүүлийн үеийн хэргийн газрын цүнхээр хангаж, аймгийн төв Улаангом сумын гудамж талбайн 25 цэгт 75 ширхэг телекамер суурьлуулах ажлыг холбогдох албан тушаалтанд уламжилж шийдвэрлүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэхэд ашиглаж байна.

Мөн эргүүл, жижүүрийн алба хаагчдыг энгэрийн бичил камер олгож алба хаагчдын аюулгүй байдлыг хангахаас гадна гэмт хэрэг, зөрчлийг баримтжуулж шийдвэрлэхэд ашиглаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх үйл ажиллагаанд ашиглахаар аймгийн ИТХ-д санал хүргүүлж гэмт хэрэгэс урьдчилан сэргийлэх зардлаас 4029000 төгрөг шийдвэрлүүлж, нисгэгчгүй камер /дрон/ худалдан авсан.

Түүнчлэн гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд бэлэн бус торгуулийн төхөөрөмж, гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан, ASAP сан, ЦЕГ-ын газрын www.police.gov.mn системийг ашиглаж байгаа бөгөөд сүүлийн үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашигласны үр дүнд хөнгөн хэргийн илрүүлэлт 65.3 хувь, хүндэвтэр хэргийн илрүүлэлт 83.3 хувь, хүнд, онц хүнд хэргийн илрүүлэлт 100 хувь байна.

Гэмт хэргийн илрүүлэлтийг урьд оны мөн үетэй харьцуулахад 4.1 хувиар өссөн байна.

Гурав. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээлэл хүлээн авах, бүртгэх ажилтай холбоотой мэдээлэл

Тус цагдаагийн газар нь 2016 онд иргэд, аж ахуй нэгж, байгуулагаас 3118 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 955 буюу 30.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1551 буюу 49.7 хувь нь захиргааны зөрчлийн шинжтэй, 591 буюу 18.9 хувь нь бусад гомдол мэдээлэл байх бөгөөд гомдол мэдээлэл гаргагчид чирэгдэл учруулахгүй, шуурхай үйлчлэхэд удирдлагын зүгээс тогтмол хяналт тавьж хуульд заасан хугацаанд шийдвэрлэх зорилтыг тавьж ажилласны үр дүнд гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 334 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, 621 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорын хяналтанд шилжүүлж нийт гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг 100 хувь шийдвэрлэсэн байна.

Шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийнхээ 847 буюу 88.6 хувийг 0-5 хоногт, 108 буюу 11.3 хувийг 6-19 хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй гомдол

мэдээллийн 1539 буюу 99.2 хувийг 14 хоногт 12 буюу 0.8 хувийг 15-28 хоногт шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн бүртгэлийг өдөр бүр аймгийн прокурорын газартай тулгалт хийж, мэдээллийн зөрүүг арилгаж ажилласан ба цагдаагийн газрын удирдлага, тасгийн дарга, ахлах байцаагч нараас бүртгэлээр болон нэгдсэн сангийн орчинд хяналт тавьж, гомдол гаргагчид 100 хувь хариуг өгч ажилласан байна.

Түүнчлэн иргэд, аж ахуй нэгж байгууллагаас жижүүрийн шуурхай албанд ирүүлсэн дуудлага, мэдээллийн дагуу дунджаар 4-6 минутанд очиж хойшлуулшгүй ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу явуулж ажилласан.

Мөн энэ онд гэмт хэргийн шинжтэй 719 дуудлага мэдээллийн дагуу хэргийн газарт шуурхай бүрэлдэхүүн үзлэг хийж, хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий 285 ширхэг эд мөрийн баримтыг хураан авч ажилласан байна.

Мөн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авсан даруйд Цагдаагийн газрын бүртгэлд оруулж, мэдээллийн санд шивсэн тухай маягтыг тэмдэглэх “Хяналтын хуудас”-ыг бичиж хэвшсэн ба нэгдсэн бүртгэлд мэдээлэл дутуу орох, орхигдох явдал таслан зогсоогдсон.

Дөрөв. Цагдаагийн алба хаагчийн сургалт, сахилга ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл

Тус цагдаагийн газраас алба хаагчдын мэдлэг үр чадварыг хөгжүүлэх, албанаас зохион байуулагдаж байгаа сургалтыг алба хаагчдын ажил мэргэжлийн онцлог, ажилласан жил, үр чадварт зохицсон шинэлэг байдлаар зохион байгуулах, албаны сургалтын чанар, үр дүнд ахиц гаргах зорилгоор “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-г тус цагдаагийн газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/08 дугаар тушаалаар баталж, албаны сургалтыг сар бүрийн 1, 3 дугаар долоо хоногийн “Лхагва” гарагт 16.00 цагаас зохион байгуулан ажиллаа.

Мөн цагдаагийн газрын төрөл мэргэжлийн тасаг, хэсгүүд дотооддоо зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулж сар бүрийн 2 дахь долоо хоногийн “Баасан” гарагт сургалт зохион байгуулж хэвшсэн.

Цагдаагийн газраас 2016 онд алба хаагчдыг хөгжүүлэхэд чиглэсэн 44 удаагийн 88 цагийн сургалтанд 1099 алба хаагч /*давхардсан тоогоор*/, мэдвэл зохих хууль тогтоомжийн 60 удаагийн 120 цагийн сургалтанд 822 алба хаагч /*давхардсан тоогоор*/, мэргэжлийн үр чадвар болон дадлагжуулах 40 удаагийн 80 цагийн сургалтанд 1100 алба хаагч /*давхардсан тоогоор*/, бие, бялдарын бэлтгэлжилтийн 75 удаагийн 150 цагийн сургалтанд 1060 алба хаагч /*давхардсан тоогоор*/ тус тус хамрагдсан байна.

Дээр дурдсан сургалтыг гаднаас багш урьж явуулахаас гадна тасгийн даргаас дээш албан тушаалтан 180 удаагийн 360 цагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Мөн цагдаагийн газрын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан сургалтаас гадна цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд орсон нэмэлт, өөрчлөлт, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар тухай бүр алба хаагчдад сургалтыг зохион байгуулж ажиллаа.

Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын төвөөс ирүүлсэн сургалтын сэдэв, эрэлт хэрэгцээ, шаардлагыг харгалзан тус цагдаагийн газраас Байгаль орчны журмын эсрэг гэмт хэргийн газрын үзлэг хийх, илрүүлэх арга тактик” сэдэвт сургалтанд 1, Сэтгэл зүйчдыг чадавхжуулах модулын сургалтанд 1, Хүний амь нас хохирсон хэргийн газрын үзлэг хийх, илрүүлэх арга, тактикийн сургалтанд 1, Цагдаагийн байгууллагын мэдээллийн сан, дүн бүртгэлийн системийн ойлголт, түүнийг ашиглах дадлага чадвар ахиулах мэдлэг олгох сургалтанд 1, Шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, арга тактик ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтанд 1, Жижүүрийн офицеруудад

тодорхой төрлийн гэмт хэргүүдийн хойшлуулшгүй ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтанд 2, “Мэргэшсэн офицер” мэргэшүүлэх сургалтанд 1, Цагдаагийн байгууллагын мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онцгой албаны нэмэгдэл болон байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагааг хөтлөн явуулах бүртгэл тооцооны талаарх мэдлэг олгох сургалтанд 1, Гэмт хэрэгтэй тэмцэх албаны алба хаагчдад зориулсан сургалтанд 2, нийт 11 алба хаагчийг Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын төвөөс зохион байгуулсан сургалтанд хамруулсан.

2016 онд мэргэжлийн болон зорилтот сургалтанд нийт 45 алба хаагчийг хамруулсан байна.

Тус цагдаагийн газрын алба хаагчдаас 2016 онд 14 офицер, 12 ахлагч нийт 26 алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил гаргаж сахилгын арга хэмжээ авагдсан байх ба нийт алба хаагчдаас тус цагдаагийн газрын сэтгэл зүйч “Сэтгэл санааны байдал”, “Бие хүний зан чанарын онцлог”-ийг тодорхойлох судалгааг авч, тухайн алба хаагчийг зөрчил гаргахад нөлөөлөх сэтгэл зүйн шалтгаан байгаа эсэхийг тодруулан, сахилга ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан.

Түүнчлэн алба хаагчдын сахилга ёс зүйг сайжруулах зорилгоор “Сахилга ёс зүйгүй хамт олон” сэдэвт аяныг зохион байгуулж, нийт алба хаагчдаар сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй байх талаар бичгээр баталгаа гаруулан авсан.

Энэ онд алба хаагчдын сахилга ёс зүйг дээшлүүлэх, гаргасан зөрчил дутагдлыг давтан гаргуулахгүй байх, сахилга ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

- ❖ Алба хаагчдаас сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй байх талаар бичгээр 2 удаа баталгаа авсан.

- ❖ “Сахилга ёс зүйгүй хамт олон” сэдэвт аяныг зохион байгуулж үр дүнг тооцсон,

- ❖ Сахилгын зөвлөгөөнийг улирал бүр хийсэн.

- ❖ Гэр бүлийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулсан,

- ❖ Офицер болон ахлагчийн зөвлөл байгуулж, сахилга ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үүднээс спортын тэмцээн уралдаан зохион байгуулсан,

- ❖ Сахилга ёс зүйн чиглэлээр 4 удаа 6 цагийн сургалт зохион байгуулсан,

- ❖ Алба хаагч нарт ахмад ажилтан нараар цагдаагийн алба хаагчийн ёс зүй, биеэ авч явах байдал, алдаа оноо, ажлын хариуцлага, сахилга батын талаар яриа хийлгэх, таниулах арга хэмжээ зохион байгуулсан,

- ❖ Гаднаас багш урьж, алба хаагчдын харилцааны соёл, бие биенээ хүндлэх ёсын талаар сургалт хийсэн,

- ❖ ЦЕГ-ын удирдлага, төвийн албадаас ирүүлсэн сахилга ёс зүйтэй холбоотой үүрэг чиглэлийг тухай бүр танилцуулж ажилласан,

- ❖ Сахилга ёс зүйг дээшлүүлэх, алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн нийтийг хамарсан соён гэгээрүүлэх арга хэмжээнүүдийг сар бүр зохион байгуулсан зэрэг ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаа. Үүний үр дүнд сахилга ёс зүйн зөрчил өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15 нэгжээр буюу 36.5 хувиар буурсан байна.

Тав. Гэмт хэрэгтэй тэмцэх нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тус аймгийн хэмжээнд 2016 онд 322 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 182 хэрэг нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг байсан ба

үүнээс 141 хэргийг буюу 77.5 хувийг нь илрүүлсэн байна. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн илрүүлэлтийг хэргийн ангилалаар авч үзэхэд хөнгөн хэргийн илрүүлэлт 65.3 хувь, хүндэвтэр хэргийн илрүүлэлт 83.3 хувь, хүнд, онц хүнд хэргийн илрүүлэлт 100 хувь байна.

Хариуцсан орон нутгийн гэмт хэргийн гаралт, эрүүгийн нөхцөл байдлыг сар бүр сумдаар нь нэгтгэн цагдаагийн газрын удирдлагад танилцуулж дүгнэлт хийж гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа, хэсгийн байцаагч, багийн цагдаа нарын хүчийг татан оролцуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэр зорилгоор “Шинэ жил”, “Сар шинэ-2016”, “Баг-1”, “Орон байр-1”, “Оюутан”, “Шатахуун түгээх станц-1”, “РС цахим тоглоом”, “Тулгалт-2”, “Архаг архичин”, “Аз од бооцоот тоглоом”, “Хальтиргаа”, “Хамгаалах бүс гар утас”, “Нийтийн тээвэр”, “Согтуу-1”, “Илрүүлэлт-Оргодол-2016”, “Тамхи-1”, “Захиргааны хяналтын уулзалт-1, 2, 3”, “Март”, “Цэргийн баяр”, “Эрх зүйн олимпиад”, “Хөршийн холбоо-1”, “Shool police”, “Түд ажиллагаа” “ИТХ-ын А/150 тоот тогтоолын хэрэгжилт”, “Гал түймэр”, “Зүүн сумдад гэмт хэрэг бууруулья”, “Хүүхдийн баяр”, “Элсэлтийн шалгалт”, “Архаг архичин”, “Сонгууль-2016”, “Дуудлага”, “Намрын нүүдэл”, “Илрүүлэлт оргодол-2016”, “Хамгаалах бүс хамгаалалтын суудал”, “Нуурын зам”, “Хөдөлгөөнт эргүүл”, “Оюутан тээвэр”, “Согтуу-2”, “Хичээлийн шинэ жил-2016”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Цохилт”, “Түд-ажиллагаа-2”, “Тамхи”, “Баг”, “Архи тамхигүй ирээдүй”, “Зэвсэг-2016” зэрэг 51 нэгдсэн болон тусгай, хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион явуулж биелэлт үр дүнг тооцон ажиллаа.

Үүний үр дүнд гэмт хэргийн гаралт 50 нэгжээр буюу 13.4 хувиар тус тус буурсан байна.

Мөн онд тус цагдаагийн газраас Цагаан сарын битүүний хурал, Дэчинравжаалан хийдээс зохион байгуулсан 12 жилтны засал, Төрийн одон медаль гардуулах ёслолын арга хэмжээ, Аймгийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн, ОХУ-тай хамтарсан хилийн яармаг худалдаа, МУ-ын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Увс аймагт айлчилах үеийн хамгаалалт, МУ-ын Их Хурлын дарга, З.Энхболд Увс аймгийн сонгогч иргэдтэй уулзах үеийн хамгаалат, Ардын хувьсгалын 95 жилийн ой, аймаг байгуулагдсаны 91 жилийн ойн хамгаалат, УИХ-ын сонгуулийн хамгаалат, Аймгийн ИТХ-ын сонгуулийн хамгаалалт, Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хамгаалалт, Увс аймгийн сум, багуудын иргэдийн хурлын төлөөлөгч сонгох сонгууль зэрэг нийтийг хамарсан 18 хамгаалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 450 алба хаагч 32160 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж ажилласан байна.

Түүнчлэн тус аймгийн Өлгий, Өмнөговь зэрэг сумдад бог малын мялзан өвчин гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/484 тоот “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” захирамж гарч, хэв журам сахиулах мэргэжлийн анги Өлгий суманд 3, Өмнөговь суманд 4, Завхан суманд 1, Улаангом суманд 3, Цагаанхайрхан суманд 1, нийт 15 постонд 45 алба хаагч, 16200 хүн/ цагийн тасралтгүй үүрэг гүйцэтгэж, хорио цээрийн дэглэм сахиулан ажилласан.

Түүнчлэн саатуулах байранд архидан согтуурч, зөрчил гаргасны улмаас 2016 онд 768 хүн саатуулагдсан ба урьд оны мөн үетэй харьцуулахад 199 хүнээр буюу 20.5 хувиар буурсан байна.

Захиргааны журмаар баривчлагдсан 38 хүн байх ба буюу урьд оны мөн үетэй харьцуулахад 182 нэгжээр буюу 82.7 хувиар буурсан байна.

Цаашид гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг гаргаж байна. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар бүлэгт хуульчлагдсан Олон нийтийн цагдаагийн ажилтныг ажиллуулахад шаардагдах хөрөнгө, зардлыг шийдвэрлэн ажилд оруулах.

2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэх хамгаалах байрны асуудлыг шийдвэрлэх.

3. Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, аттестатчлах, тоог цөөрүүлэх.

4. Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зэрэг саналыг дэвшүүлж байна.

Зургаа. Нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийн хэрэгжилт

Тус цагдаагийн газраас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд туслах, тухайн байгууллагуудаас зохион байгуулж байгаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор хамтран ажиллаж байна.

Тухайлбал хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, буюу хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагатай дараах байдлаар хамтран болон дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласан. Жишээ нь:

- Боловсрол соёлын газар, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжилийн хэлтэс, Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулахад нь хамтран ажиллаж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөв.

- Аймгийн Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран Ерөнхий боловсролын бага ангийн сурагчдын дунд “Миний мэдэх замын хөдөлгөөн” сэдэвээр гар зургийн уралдаан, Эрүүл мэндийн газартай хамтран дунд, ахлах ангийн сурагчдын дунд “Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвээр зохион бичлэгийн уралдаан зохион байгуулсан ба эдгээр арга хэмжээнд цагдаагийн газраас дэмжлэг үзүүлж, уралдаан тэмцээнийг тодорхой хэмжээгээр санхүүжүүлсэн.

- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйн зөвлөлтэй хамтран “School police” арга хэмжээг жил бүр зохион байгуулан ажиллаж байна.

- Улаангом сумын цэцэрлэгүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2016”, ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Ногоон гэрэл, Цагаан шугам-2016” тэмцээнүүдийг Эрүүл мэндийн газар, Хүүхэд Гэр Бүл Хөгжлийн Хэлтэс, Улаан загалмайн 01-дөөтэй хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

- “Эрх зүйн” олимпиадыг аймгийн Боловсрол соёлын газартай хамтран 5 дахь жилдээ зохион байгуулсан ба цагдаагийн газраас эхний 3 байранд орсон багш, сурагчдыг шагнасан.

- Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн санамж, сэрэмжлүүлгийг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран явуулсан.

Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагатай дараах байдлаар хамтран болон дэмжлэг, туслалцаа үзүүлж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллав. Үүнд:

- Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага, тараах материал хэвлүүлж иргэдэд тараан ажилласан.

- Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Прокурорын газартай байгаль орчны эсрэг гэмт хэргийн талаарх мэдээллийг байнга солилцон харилцан бие биедээ дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

- Онцгой байдлын газраас зохион байгуулж байгаа сургалтыг цагдаагийн газрын танхим, сургалтын хэрэгслүүдийг ашиглуулан зохион байгуулан дэмжлэг үзүүлэн ажиллаа.

- Увс нуурийн ай сав газруудын тусгай хамгаалттай газрын нутгийн захиргаатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

- Мэргэжлийн хяналтын газраас хууль бус аргаар ашигт малтмал олборлож байгаа үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд цагдаагийн газраас дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж гар аргаар алт олборлож байгаа иргэдийг татан буулгасан. Мөн онд “Цохилт” тусгай арга хэмжээг хамтран зохион байгуулсан.

- Байгаль орчин аялал жуулчлалын газраас сумдын байгаль хамгаалагч нарт Ойн тухай хууль тогтоомжоор сургалт зохион байгуулахад цагдаагийн газраас 1 цагийн сургалтыг явуулсан.

- Увс аймгийн төв Улаангом суманд их хэмжээний аадар бороо орж зарим иргэдийн орон гэр үер автсан байгалийн аюулт үзэгдэл, малын гоц халдварт Мязан өвчний хорио цээрийн үед тус цагдаагийн газраас Онцгой байдлын газар, аймгийн Мал эмнэлэг үржлийн газартай хамтран ажилласан.

Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагатай дараах байдлаар хамтран ажиллав. Үүнд:

- Авто тээврийн үндэсний төвийн Увс аймаг дахь салбар, Албан журмын даатгалын холбооны Увс аймаг дахь салбар, тус аймагт үйл ажиллагаа явуулж буй авто курсын холбоо, “Сайн тус” төрийн бус байгууллагын ажилтан алба хаагч нарыг оролцуулан “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулж ажиллаа.

- “Хархираан цуурай-103.3” радиотой хамтран жолооч, зорчигч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 27 дахь заалт “согтуугаар ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохогүй байх”, 32 дахь заалт “хөдөлгөөнд оролцохдоо тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах”, 35.1.2 дахь заалт “Хамгаалах бүс хэрэглэх”, “мотоцикль жолоодохдоо хамгаалах малгай хэрэглэх, хамгаалах малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэхгүй байх”, 44.1 дэх заалт “явган хүний гарцаар гарч байгаа хүнд зам тавьж өгөх” гэсэн заалтуудаар сурталчилгааг нэвтрүүлэн хамтран ажилласан.

- Хотын хөгжил, цэцэрлэгжүүлэлтийн газраас аймгийн төвийн замд босоо болон хэвтээ тэмдэг тэмдэглэгээ хийхэд мэргэил арга зүйн зөвлөгөө өгсөн.

- “Сайн тус” төрийн бус байгууллагатай хамтран согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож эрх хасагдаж хугацаа нь дуусаж эрхээ сэргээлгэх хүсэлт гаргасан 69 иргэнд 6 удаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрэм, сэтгэл зүй, эрүүл мэнд, архи дан согтуурахын хор уршигийн талаар сургалт зохион байгуулж ажилласан.

Тус цагдаагийн газар нь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, аймгийн “Архидалт мансуурлын эсрэг ассоциаци”, “Эрүүл идэвхитэй амьдралын клуб”, аймгийн ГХУССЗөвлөл, бүх шатны засаг дарга, ХЦ-ийн 0245, 0311-р анги, Тагнуулын газар, Шүүх, прокурорын байгууллага, Шүүхийн шинжилгээний алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Иргэний нисэхийн Увс аймаг дахь салбар, аймгийн өмгөөллийн холбоо, “МВС”, “УВС нам бус телевиз”, УВС телевиз, 103.3 радио, Гэр бүл хөгжлийн хэлтэс, Хүний эрхийн хороо, багийн нийгмийн ажилтан, ерөнхий

